

## Гарчиг

1.	ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	2
1.2.	Төслийн товч танилцуулга .....	2
1.3.	Уурхайн календарьчилсан төлөвлөгөө .....	3
1.4.	Уурхайн ажиллах горим .....	3
1.5.	Уулын ажлын төлөвлөгөө.....	3
1.6.	Ил уурхайн ашиглалтын систем .....	3
1.7.	Баяжуулах технологи .....	5
2.	БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	9
2.1.	Цаг уур, уур амьсгал .....	9
2.2.	Гадаргын ус .....	9
2.3.	Хөрсний төлөв байдал .....	10
2.4.	Ургамлан бүрхэвч .....	11
2.5.	Бүрэгхангай сумын нийгэм эдийн засгийн судалгаа .....	11
3.	ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ .....	13
4.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ .....	14
5.	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	15
5.1.	Ордын ашиглалтын үед сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	15
5.2.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	19
5.3.	Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	19
5.4.	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө .....	19
5.5.	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө .....	20
5.6.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	21
6.	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....	22
6.1.	БОМТ-ний хэрэгжилтийн талаар нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө .....	24

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Төслийн талбайн координат цэг.....	2
Хүснэгт 2.	Календарьчилсан төлөвлөгөө .....	3
Хүснэгт 3.	(ХШ 967-968)-ын хооронд дахь ашиглалтын технологийн схем .....	4
Хүснэгт 4.	(ХШ 969-971a)-ын хооронд дахь ашиглалтын технологийн схем .....	4
Хүснэгт 5.	Ил уурхайн үндсэн хэмжээс .....	5
Хүснэгт 6.	Ажиллах горим.....	6
Хүснэгт 7.	Хөрсний химийн үндсэн шинж .....	11
Хүснэгт 8.	Хөрсний механик бүрэлдэхүүн .....	11
Хүснэгт 9.	Болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээний нэгдсэн дүн.....	13
Хүснэгт 10.	Ордын ашиглалтын үед сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	15
Хүснэгт 11.	Нөхөн сэргээлтийн зардал .....	19
Хүснэгт 12.	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө .....	19
Хүснэгт 13.	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө .....	20
Хүснэгт 14.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал.....	21
Хүснэгт 15.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал.....	23
Хүснэгт 16.	БОМТ тайлагнах төлөвлөгөө.....	24
Хүснэгт 17.	БОМТ-ний нийт зардал.....	25

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Төслийн талбайн байршил .....	2
Зураг 2.	Драгын олборлолт .....	4
Зураг 3.	Уурхайн дэвсгэр зураг.....	5
Зураг 4.	Угаах үйлдвэр-1 баяжуулах технологийн схем .....	6
Зураг 5.	Угаах үйлдвэр-2 баяжуулах технологийн схем .....	7
Зураг 6.	Угаах болон цэвэршүүлэх далан .....	8

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

**Төсөл хэрэгжүүлэгч:** “Гэрэлт шинэчлэл” ХХК

УБД: 9011071145, РД: 5046483

**Төслийн нэр:** “Бүрэг алтны шороон ордыг ил болон драгын аргаар ашиглах” төсөл

**Төслийн зорилго:** Уул уурхайн үйлдвэрлэл хөгжүүлж алт олборлох

**Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар:** MV-021324

**Төслийн талбайн байршил:** MV-021324 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг Бүрэг хэмээх газар. Улаанбаатар хотоос баруун хойш 210-250 км-т, Бүрэгхангай сумаас 40 км-т тус тус байрлана.

*Хүснэгт 1. Төслийн талбайн координат цэг*

№	Уртраг	Өргөрөг
1	104° 20' 04.93"	48° 14' 40.82"
2	104° 20' 13.94"	48° 14' 49.83"
3	104° 20' 13.85"	48° 14' 56.88"
4	104° 20' 21.03"	48° 14' 56.92"
5	104° 20' 23.51"	48° 14' 59.04"
6	104° 20' 23.47"	48° 14' 02.12"
7	104° 20' 26.25"	48° 15' 02.12"
8	104° 20' 40.93"	48° 15' 16.82"
9	104° 20' 40.93"	48° 14' 40.82"



*Зураг 1. Төслийн талбайн байршил*

### 1.2. Төслийн товч танилцуулга

“Гэрэлт шинэчлэл” ХХК нь Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших Бүрэг нэртэй газар нь MV-021324 дугаартай 43.1 га газар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй болно. Уг орд газар нь Улаанбаатар хотоос баруун хойд зүгт 210-250 км, Бүрэгхангай сумын төвөөс зүүн зүгт 40 км-т байрладаг.

Бүрэг нэртэй алтын шороон ордын нөөцийг ЭБМЗ-ийн 2014 оны 07-р сарын 09-ний ХХ-

12-17 тоот дүгнэлт, АМГТГ-ын даргын 2014 оны 8-р сарын 04-ний н-132 тоот тушаалаар ашигт малтмалын улсын нэгдсэн нөөцөд бүртгэхдээ нөөцийг зүсэлтийн аргаар хүлээн авсан. Харин ЭБМЗ-ийн 2019 оны 06-р сарын 27-ны Т/19-11-03 тоот дүгнэлт, АМГТГ-ын даргын 2019 оны 08-р сарын 02-ны т/117 тоот тушаалаар хүлээн авсан ТЭЗҮ-д үйлдвэрлэлийн нөөцийн тооцоог блокийн аргаар боловсруулсан байна.

Цаашид үйлдвэрлэлийн нөөцийн тооцоог ТЭЗҮ-д тусгагдасны дагуу тооцоолон төлөвлөсөн. 2022 оны олборлолтын үеийн дундаж бохирдол 3.418 %, хаягдал 4.89 % -тайгаар олборлоно.

2022 он ТЭЗҮ батлагдаснаас хойшхи ашиглалтын 1-р жилд хамаарна. 2022 онд 2022 онд тус ордын С-1, С-2, С-3, В-20-1, В-20-2, В-20-3 блокуудыг бүрэн олборлож дуусах бол С-1-1 блокийн 61.5 %-ийг ашиглана. С-1-1 блокийн үлдэгдэл хэсгийг 2023 онд ашиглана. 2022 онд ашиглалтын хаягдалгүйгээр олборлолтын үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн ба бохирдлын хувийг ашиглалтын блок тус бүрээр ТЭЗҮ-д тусгагдасны дагуу тооцлоо. 2022 онд уурхайгаас нийт 285.61 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 139.4485 мян.м<sup>3</sup> элс /элсэн дэх металлын хэмжээ 22.1 кг/ олборлоно.

### 1.3. Уурхайн календарьчилсан төлөвлөгөө

Хүснэгт 2. Календарьчилсан төлөвлөгөө

№	Ашиглалтын хугацаа	Хөрс хуулалт, м <sup>3</sup>	Элс олборлолт, м <sup>3</sup>	Кхх, м <sup>3</sup> /м <sup>3</sup>
1	2023-05 сар	50000	25000	2
2	2023-06 сар	50000	23390	2.14
3	2023-07 сар	50000	25000	2
4	2023-8 сар	50000	25000	2
5	2023-9 сар	50000	25000	2
6	2023-10 сар	35600	15600	2.28
	Нийт	285600	139400	2.05

### 1.4. Уурхайн ажиллах горим

Уг орд нь 2023 оны 4-р сараас бэлтгэл ажил эхэлнэ. Уулын ажил хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 10 цаг байна. 2025 оны 5-10-р саруудад хаалт нөхөн сэргээлтийн ажил хийнэ. Монгол улсын хөдөлмөрийн хуульд заасны дагуу жилд амрах баяр ёслолын хоног цаг тооцон хоног ажиллахаар тооцлоо.

### 1.5. Уулын ажлын төлөвлөгөө

Ашиглалтын нийт хугацаанд 130.5 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 150.0 мян.м<sup>3</sup> элс олборлох ба хөрс хуулалтын итгэлцүүр 1.11 м<sup>3</sup>/м<sup>3</sup> байна. 2023 оны 07 дугаар сараас уулын ажил эхлэх ба В-1 блокоос олборлолт явуулж эхэлсэн үргэлжлэн В-1 блок олборлож дуусгана.

### 1.6. Ил уурхайн ашиглалтын систем

Чулуулгийн физик, механик шинж чанар Ордын олборлолтын уул-техникийн нөхцөлийг тодорхойлох, элсний шинж чанарыг Ханлаб лабораторид өгч шинжлүүлсэн байдаг.

Орд нь нийт 8 блокоос бүрдэх бөгөөд ХШ-969-өөс ХШ-971а-ын хоорондох блокийн хөрс дунджаар 4.5-8м хүртэл бөгөөд тус блокуудыг авто тээвэртэй, дотоод овоолго үүсгэн ашиглана. ХШ-967 болон ХШ-968-ын хооронд дахь блокийн алт агуулсан элсний давхарга нь дунджаар 6м, 2.5-3.2 градусын налуутай, хэвтэш маягийн, зүүн хойно баруун урагш сунаж тогтсон шороон орд юм. Ордод өмнө нь драгаар олборлолт явуулж байсан.



Зураг 2. Драгын олборлолт

Хүснэгт 3. (ХШ 967-968)-ын хооронд дахь ашиглалтын технологийн схем

Ашиглалтын систем	Үндсэн ажил	Технологийн процесс
Автотээвэртэй дотоод овоолго	Хөрс хуулалт	Ухах
		Ачих
		Тээвэрлэх
		Овоолох (гадаад ба дотоод овоолго)
	Элс олборлох	Ухах
		Ачих
		Тээвэрлэх
		Угаах үйлдвэр

Хүснэгт 4. (ХШ 969-971а)-ын хооронд дахь ашиглалтын технологийн схем

Ашиглалтын систем	Үндсэн ажил	Технологийн процесс
Автотээвэртэй хөрс хуулалт болон драгын аргаар элс угаах	Хөрс хуулалт	Ухах
		Ачих
		Тээвэрлэх
		Овоолох (гадаад ба дотоод овоолго)
	Элс олборлох (драг)	Ухах
		Ачих
		Тээвэрлэх
		Угаах үйлдвэр

#### Ил уурхайн ашиглалтын системийн үндсэн хэмжээс

Ил уурхайн үндсэн хэмжээснүүдийг уурхайн тоног төхөөрөмж болон хүчин чадалд тулгуурлан сонгосон.

**Доголын өндөр:** Элсний бохирдлыг бага байлгах, ухаж ачих тоног төхөөрөмжийн


ажиллах нөхцөл зэргийг үндэслэн ил уурхайн ажлын доголын өндрийг Нд=2.5м байхаар сонгосон.

**Ажлын доголын хажуугийн өнцөг:** Ажлын доголын хажуугийн өнцгийг чулуулгийн шинж чанар, аюулгүй ажиллагаа зэргийг тооцож  $\alpha=60$  градус байхаар сонгосон.

**Ил уурхайн ерөнхий хажуугийн өнцөг:** Уурхайн ашиглалтын технологийн элементүүд болох ажлын болон ажлын бус доголын өндөр ба доголын өнцөг, тээврийн ба аюулгүйн тавцангийн өргөн зэргийг тооцон уурхайн хажуугийн өнцгийг 45-50 градус байхаар сонголоо.

Хүснэгт 5. Ил уурхайн үндсэн хэмжээс

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
1	Ажлын доголын өндөр	м	2.5
2	Ажлын бус доголын өндөр	м	5
3	Ажлын доголын хажуугийн өнцөг	Градус	60
4	Ажлын бус хажуугийн өнцөг	Градус	45-50
5	Замын өргөн	М	10
6	Замын налуу	Промил	80



Зураг 3. Уурхайн дэвсгэр зураг

### 1.7. Баяжуулах технологи


2023 оны ашиглалтын үйл ажиллагаандаа өмнөх онуудад ашиглаж байсан Геомаш-30 маркийн угаах төхөөрөмж, 6s-7.6 маркийн баяжуулах ширээ, Д-320 маркийн усны насос зэргийг ашиглана.

№	Үзүүлэлт	Үйлдвэр-1	Үйлдвэр-2
1	Төслийн ажиллах хуанлийн хоног	92	307
2	Төслийн засвар үйлчилгээний хоног	3	6
3	Төслийн нийт баяр ёслолын хоног	3	8
4	Төслийн нийт ажиллах бодит хоног	86	293
5	Хоногт ажиллах бодит цаг	20	20
6	Цагийн хүчин чадал, м <sup>3</sup> /цаг	50	54.4
7	Цагийн хүчин чадал, тн/цаг	82.5	89.8
8	Жилийн хүчин чадал, м <sup>3</sup> /жил	53,867.90	100,000

### Баяжуулах технологийн горим

#### Угаах үйлдвэр-1


Скруббер бутарын угаан баяжуулах үйлдвэр нь хүрдэн шигшүүрээр 20 мм-ийн тороор ангилна. +20 мм-ийн ангиллын бүтээгдэхүүнийг галийн овоолгод хураана. -20 мм-ийн ангиллын бүтээгдэхүүн гүн дүүргэлтийн шлюзээр баяжуулна. Гүн дүүргэлтийн шлюз дээр тогтсон бүтээгдэхүүнийг сэгсрэх ширээгээр гүйцээн баяжуулна. Скруббер бутараар угаан баяжуулах технологийн схемийг харуулав.



Зураг 4. Угаах үйлдвэр-1 баяжуулах технологийн схем

#### Угаах үйлдвэр-2

Гүн болон нам дүүргэлтийн шлюзэн дээр тогтсон -20+8мм болон -8 мм ангиллын баяжмалыг тунаах машинаар дамжуулан сэгсрэх ширээгээр гүйцээн баяжуулна. Гүйцээн баяжуулахад ирсэн баяжмалыг баяжуулах ширээгээр баяжуулах ба ширээний завсрын бүтээгдэхүүнийг эргэлтийн ачаалал болгон өгнө. Баяжуулах ширээний баяжмалыг соронзон ялгагчаар ялган шлихийн алтыг авна. Гүйцээн баяжуулах үйлдвэрийн баяжуулах ширээний хаягдлыг драгийн хаягдалд нийлүүлэн дотоод овоолго болгон хаяна. Элс угаан баяжуулах технологийн схемийг харуулав.



Зураг 5. Угаах үйлдвэр-2 баяжуулах технологийн схем

### Хаягдлын нуур

Хаягдлын усан сангийн эзлэхүүнийг тооцохдоо угаан баяжуулах цехийн үйл ажиллагааг тасралтгүй 2 хоног хангах боломжийг бүрдүүлэхээр төлөвлөсөн. Технологийн усны хоногийн хэрэглээ  $3901.8 \text{ м}^3$  бөгөөд  $37,050 \text{ м}^3$  эфель хуримтлагдах бөгөөд сангийн багтаамж нь

$$V_{\text{усан сан}} = W_{\text{ус}} * 2 = 3901.8 * 2 = 7803.7 \text{ м}^3 + 37050 = 44853.7 \approx 50000 \text{ м}^3$$

цэвэр усны хоногийн хэрэглээ нь  $585.3 \text{ м}^3$  бөгөөд цэвэр усны сангийн багтаамж нь –ээс багагүй байх шаардлагатай.

$$V_{\text{цэвэр ус}} = W_{\text{цэвэр ус}} * 2 = 585.3 * 2 = 1170.6 \approx 2,000 \text{ м}^3$$

### Тунаах болон цэвэршүүлэх далан

Эндээс үзэхэд үйл ажиллагаа явагдах 1 жилийн хугацаанд хаягдлын нуурын багтаамж хангалттай хүрэлцэхээр байна. Уурхайн талбайд үер борооны ус орж ирэхээс хамгаалан хамгаалалтын суваг байгуулж уг сувгийг эргэлтийн усан сангийн далантай холбож үерийн усыг уурхайд ашиглах боломжтой.



Зураг 6. Угаах болон цэвэршүүлэх далан

### Үйлдвэрийн бүтэц ба дэд бүтэц

Үйлдвэрийн бүрэлдэхүүн нь тус ордоос элс олборлох, тээвэрлэх технологи болон түүний үйл ажиллагааг хэвийн явуулах, төлөвлөсөн хүчин чадлыг бүрэн эзэмших нөхцөл, үйл ажиллагаагаар тодорхойлогдоно. Тус уурхай нь дараах хэсгүүдээс бүрдэнэ.

- ✓ Ил уурхай
- ✓ Элс угаан баяжуулах хэсэг
- ✓ Захиргаа, ажилчдын байрууд
- ✓ Цахилгаан хангамж /дизель станц/
- ✓ Усан хангамж /гүний худаг/
- ✓ Засварын газар
- ✓ Хоолны газар /сэндвич барилга/
- ✓ Тэсрэх материалын болон бусад агуулахууд
- ✓ Уурхай орчмын замууд зэрэг объектууд багтана.

Хүний нөөцийн хувьд орон нутгийн ажилчдыг ажлын байраар хангах бодлогыг эхний ээлжид авч үзэх ба орон нутгийн иргэдэд сургалтын тэтгэлэг олгох, мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах, дадлагажуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.



## 2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 2.1. Цаг уур, уур амьсгал

Улирлын уур амьсгалын нөхцлөөр хавар намар, өвөл зуны үргэлжлэх хугацаа хосоороо ойролцоо байгаа нь эх гэзрын уур амьсгалын хахир ширүүн шинжийг илтгэж байна. Жилийн улирлын хугацаа нь тухайн үеийн цаг агаар бүрэлдэн бий болох онцлогоос хамааран зохих хэлбэлзэлтэй байх боловч жилээс жилд 5-7 хоногоос илүү хэлбэлзэхгүй.

Ашиглалтын талбай орчмын орд ашиглах газрын орчимд уур амьсгал бүрдүүлэгч үндсэн хүчин зүйлийн нэг нарны цацраг, нарны гийгүүлэх үргэлжлэх хугацаа нь орон нутгийн онцлогтой боловч бүсийн горимыг дагадаг. Жилдээ хэвтээ гадарга дээр 2850 мДж/м<sup>2</sup> шулуун цацраг, 4900 мДж/м<sup>2</sup> орчим нийлбэр цацраг ирж, нарны өндөр хамгийн бага байх өвлийн сар өдрүүдэд бага (нийлбэр цацраг 12 дугаар сард 150 мДж/м<sup>2</sup>) байснаа алгуур нэмэгдэж 5-6 дугаар сард нийлбэр цацраг 560-690 мДж/м<sup>2</sup> болтлоо өсч улмаар үүлшил, нарны өндөртэй уялдан буурч намар өвлийн горимд шилжиж байдаг нь аливаа аж ахуйн ажлын онцлог, голчлон гадаа хээрийн ажил хөдөлмрийн гол нөлөө ялгааны нэг үндэс болж өгдөг. Нарны цацрагийн тэнцэл 11 –ээс 2 дугаар сарын дунд хүртэл алдагдал ихтэй сөрөг утгатай байдгаас газар шороо өнгөнөөсөө гүнрүүгээ хөлдөлт үргэлжилж байдаг.

Салхины өөр нэгэн онцлог шинж бол салхигүй нам гүм байх давтагдал юм. Энэ онцлог талбай орчимд жилийн аль ч улиралд ойролцоогоор YII сард 32.0% , I, X сард 23-36% болж IY сард салхи ихтэйгээс бага шиг буурч 23.0% байгаа нь хонхор, хотгор нутгийг бодвол голын хөндий учир салхирхаг нутагт тооцогдоно. Энэ нь салхины хурдаар ч тодорч байна. Салхины чиглэлийн дундаж хурд зонхилох чиглэлүүдийнх бусад зүгүүдээс их байдаг. Тухайлбал зүүн өмнөөс-зүүн хойд чиглэлийнх бусад чиглэлүүдээс давамгайлж хавар, намрын саруудад бүр дахин нэмэгддэг. Эдгээр чиглэлийн дундаж хурд 2.6-7.4м/с болж, мөн зүүн, баруун зүгүүдийнх 0.0-3.0м/с хүрч бусад зүгүүдийнх 2.9-6.2м/с байна. Салхины жилийн дундаж хурд 2.8 м/с, харин намар салхи ихэсдэг. IY-Y сард 5.4-7.4м/с, өвлийн салхи багатай XII-II сард 1.0-1.3м/с бусад саруудынх 1.3-2.8м/с байгаа нь манай орны салхи багатай биш нутаг, говь цөлөөс эрс бага байдаг. Салхины хурдны 2 их (хавар, намар), 2 бага (өвөл, зуны) утгуудтай зүй тогтол хадгалагдаж байна. Салхины хамгийн их хурд бараг сар бүхэнд 10-15м/с, харин хаврын саруудад 14-24 м/с хүрнэ. Жилийн 23-50 гаруй хоногт 10м/с –ээс их салхитай, хүчтэй салхины хурд 16м/с давж байдаг. Машин техник, ер нь эгц босоо гадаргад салхи 35кг/м<sup>2</sup> (0.4 гПа) ачаа үйлчлэл үзүүлж ажил саатаж болох байна. 20 жилд тохиолдох тооцооны их хурд газар орчинд 28м/с, 100м –т 39м/с, 200м –т 43м/с тус тус хүрэх боломжтой. Бас жилдээ 19-25 өдөр цасан шуурга, 23 өдөрт шороон шуурга шуурч байгаагийн ихэнх нь 3-5 сард байна. Ийм учраас салхины ба ялангуяа хаврын саруудад газар шорооны ажлын үед их хэмжээний тоос шороо гарч агаар орчинд нөлөөлж, ачих тээвэрлэх газар шорооны ажлын нөлөөгөөр орчиндоо салхины чиглэл, хурднаас хамаарч багагүй тоос, шорооны бохирдолт болох магадлалтай байна.

### 2.2. Гадаргын ус

Судалгааны талбайн баруун талаар урсах Туул гол түүний томоохон цутгалан Хар бухын гол, Нарийн гол, жижиг салаанууд болох Ар наймган, Хайлааст, Бичигт хошууны гол болон Цайдам, Хүйтэн, Их цагаан зэрэг нуурууд, жижиг булгууд гадаргуугийн усан сүлжээг бүрэлдүүлдэг. Тус бүс нутагт хамгийн анх гидрогеологийн судалгааг 1979-1981 онд Дарханы ГХЭ-ийн Заамарын анги Туул голын хөндийн доод хэсэгт 1:50000-ын эрэл-зураглалын ажил явуулж /Д. Жамцаа, В. Довжид, Д.Лхагвасүрэн 1981 он/ Туул голын дэнж түүний баруун цутгал Урт-Сайр, Баянбулаг, Цагаанбулаг, Улаан эрэг, Хайлаастын амуудад алтны өндөр

агуулга бүхий голын хурдас илрүүлэн, талбайн хэмжээнд уст цэгүүдийн бүртгэл, ус агуулагч хурдас давхаргуудыг ангилан ялгажээ. Энэ бүс нутагт орших шороон ордын гидрогеологийн судалгааны ажил 1982 оноос эхлэн эрчимтэй хийгдэж иржээ. 1980-аад оны сүүлээс Туул голын баруун цутгалан Баянголын адаг орчимд Туул голд гидрометрийн пост ажиллуулж Туул голын урсацын жилийн хэлбэлзэл, усны чанарын судалгааг явуулж Хайлааст, Баянгол, Туулын дэнжийн хэсэг, Тосон, Цагаан булаг зэрэг олон орд газрын ордын гидрогеологийн судалгаа хийж, шавхалт түршилтын ажлууд хийгдэж газрын доорх усны үндсэн параметруудийг тогтоожээ. /ДГХЭ-ийн Туулын 3-р анги, Ш.Баярсайхан, Д.Жаргалан, Бубеников.В.Г. 1986-1988; 1989-1992 он/. Хайлаастын ордыг ашиглах, уурхайн тосгон байгуулах түүний ус хангамжийн судалгааг хуучин нэрээр ЗХУ-ын ПНИИИС гидрогеологи, инженер геологийн судалгааг явуулж Цагаан булгийн эхэнд тосгон байгуулах, түүний ус хангамжийн цооногуудыг ашиглалтанд оруулсан байна.

Туул голын ус хурах савын хэмжээнд 44013 км<sup>2</sup> талбайд жилд 818.0 сая шоо м газрын доорхи усны нөөц баялагтай байж болох тооцоо гаргасан байдаг. Туулын ай савын хэмжээнд тархсан хурдас чулуулагийн нас, литологийн төрлийг нэгтгэж, тэдгээрийн нүх сүвшилт зонхилсон, эсвэл ан цавшилт зонхилсон байдлаар ангилж газрын доорхи усны судлагдсан түвшин хөдөлгөөний төрх зэрэг хүчин зүйлийг харгалзаг ай савын хэмжээнд ус агуулагч 10 бүрдэл, ус агуулагч ан цавлаг 5 бүсийг ялгаж газрын доорхи усны 1 км<sup>2</sup> талбайд байж болох нөөц баялагаар нь 7 төрөлд хуваасан байдаг.

Туул голын хөндий нь өндөр өргөгдсөн, уулсаар хүрээлэгдсэн, эрс тэс уур амьсгалтай, хүйтний улирал урттай байдаг онцлогтой. Зуны улиралд эх газрын дулаан хуурай нөхцөлтэй байдаг тул хур тундас нь аадар шинжтэй ордог өвөрмөц нутаг гэж үздэг. Жилд унах хур тундасны олон жилийн дундаж хэмжээ 258.1 мм байх бөгөөд үүний 48.4% нь нийлбэр ууршилт, үлдэх 51.6% нь гадаргын болон газрын доорх усны тэжээгдэл болдог гэсэн судалгааг Туул голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн баг хийсэн байдаг. Туул гол, Тосонгийн голын орчим орсон аадар борооны эрчим, хур тундасны хэмжээний тухай тодорхой мэдээлэл байхгүй ойролцоогоор 40-50 мм орчим байдаг гэж үздэг. /2016 он “Шижир алт” тосгоны орчим/ Энэхүү ай савд Туулын, Урд Туулын гэсэн 2 томоохон региональ хагарал байдгийг судлаачид тогтоосон байдаг. Уг ай савыг хүрээлэн байгаа уулс нь газрын доорхи усны тэжээлийн бүс, хотгор хуримтлал нь зөөгдөл хөлийн бүс болдог. Уулс хоорондын артезын ай савын хэмжээнд палеозой, доод цэрд, неоген, дөрөвдөгчийн хурдасны устай бүрдлүүд, устай тектоникийн ан цавын бүс тус тус тархсан байна.

Туул голын хөндийн өргөн нь 100 м-ээс километр илүү, хөндийн хөндлөн огтлолын хэлбэр нь гэвш маягтай, хоёр тал нь ижил бус бөгөөд хажуунаасаа уулсаар шахагдсан байдаг. Гольдролын өргөн нь 40-60 м, гүн нь харгиан дээрээ 0.4-0.5 м, бусад газраа 2 м түүнээс илүү гүнтэй, ихээхэн тахиралдсан салаа, булан тохой, хар ус ихтэй. Эрэг нь намхан 0.6-1.5 м, тасархай, зарим газраа тэгширсэн, голдуу элсэнцэр-шавраас тогтоно.

Голын усны түвшин нь хур тунадсын хэмжээнээс шууд хамаарч 1.2-1.3 м хэлбэлзэнэ. Өвөлдөө зарим газраа тэс хөлддөг, зундаа үертэй үед 205 м<sup>3</sup>/сек хүртэл ус өнгөрөөдөг, урсгалын хурд нь 1.2 м/сек хүрнэ. Гольдролын налуужилт нь 0.001. Голын ус нь цэнгэг /0.2-0.4 г/л/, гидрокарбонат-сульфат-натрийн найрлагатай.

### **2.3. Хөрсний төлөв байдал**

*Хөрсний агро-химийн болон ус-физикийн шинж чанар.*

01 цэгийн хөрсний шинж чанар: Аллювийн элсэнцэр бараан хөрсний нийт үе давхаргад урвалын орчин (рН<sub>1:2.5</sub>) 6.25-8.10 буюу сул хүчиллэгээс шүлтлэг орчинтой, карбонатын давсжилт өнгөн үеээс илрээгүй, харин 12 см-ийн гүнээс сул эрчимтэй илэрсэн (0.85-6.18%).

Ялзмагт үеийн зузаан нь 12 см. Ялмагийн бодис буюу органик бодисын агууламж 0.719-2.594% буюу хөрсний үе давхаргад органик бодисын агууламж хэвийн байна. Хөрсөн дэх нийт хялбар уусах давсжилт буюу хөрсний цахилгаан дамжуулах чадвар (ЕС) нь 0.074-1.013 dS/m байгаа нь бага давсжилттай байна. (Хөрсний ЕС нь 1.2 dS/m-ээс дээш байгаа тохиолдолд бага давсжилттай, 8.64 dS/m-ээс дээш бол хэт их давсжилттай гэж үзнэ).

Хөрсний үржил шимийн үзүүлэлт болох хөдөлгөөнт фосфор 0.91-2.68 мг/100г буюу хэвийн хангамжтай өнгөн үеэс доод үе давхарга руу эрс бууралттай, кали 4.5-25.7 мг/100г буюу хэвийн хангамжтай байна (Мачигины хангамжийн зэргээр үнэлэв).

Хүснэгт 7. Хөрсний химийн үндсэн шинж

Зүсэлтийн дугаар	Гүн, см	pH <sub>H2O</sub> (1:2.5)	CaCO <sub>3</sub> %	Ялмаг %	ЕС <sub>2.5</sub> dS/m	Хөдөлгөөнт, мг/100г	
						P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
01	0-10	7.49	1.22	2.427	0.167	1.96	21.8
	10-30	7.66	3.01	2.055	0.185	1.68	20.6

Энэ хөрсний механик бүрэлдэхүүнд бүдүүн ширхэгтэй хэсэг элс давамгайлсан элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна. Хөрсний хэсгүүдийн харьцаа нь 0-10 см-т элсэн хэсэг 66.0%, нарийн хэсэг 34.0% байгаа нь элсэнцэр фракц давамгайлсан буюу элсэнцэр хөрстэй байна. Доод үе давхарга руу нарийн ширхэгтэй хэсгийн эзлэх хувь хэмжээ бага зэрэг нэмэгдэж элсэрхэг шавранцар болж байна.

Элсэнцэр хөрс нь ус чийг тогтоон барих чадамж муу ч чийгийн хангамж их нөхцөлд ургамлын үндэс амьсгалах боломжийг нэмэгдүүлдэг, ургах орчин нөхцөлийг бүрдүүлдэг эерэг нөлөөтэй.

Хүснэгт 8. Хөрсний механик бүрэлдэхүүн

Зүсэлтийн дугаар	Гүн, см	Ширхгийн хэмжээ, % (мм-ээр)			Механик бүрэлдэхүүний нэр
		Элс (2-0.05мм)	Тоос (0.05-0.002мм)	Шавар (< 0.002мм)	
01	0-10	50.4	34.4	15.2	Хөнгөн шавранцар
	10-30	52.3	33.1	14.6	Хөнгөн шавранцар

#### 2.4. Ургамлан бүрхэвч

Төслийн талбай нь ургамал газарзүйн мужлалаар Евразийн шилмүүст ой, нуга хээрийн их муж, чийглэгдүү хэвшинжийн Дорнод Азийн муж, Орхон-Туулын нам уулсын тойрогт хамаарагдана (Монгол улсын Үндэсний атлас, 2009). Монгол орны физик газарзүйн мужлалаар Хангайн уулт их муж, Орхон Туулын савын бэсрэг уулсын муж, Орхон-Ерөө голын тойрогт багтана (Даш, 2000).

Уулын хээрийн энэ бүс нутагт үетэн-алаг өвст, үетэн-шарилжит, сөөг-алаг өвст бүлгэмдлүүд зонхилоно. Эдгээр бүлгэмдлүүд дотор хялгана, биелэг өвс, шарилж зонхилохоос гадна харгана, тавилгана, боролзогоно зарим газартаа одой хайлаас зэрэг ургамлууд уулын бэл хажуу, дээд хэсэг, гуу жалгаар ургана. Мөн хэсэг газарт дэрст бүлгэмдэл тохиолдоно.

Газрын хотгор гүдгэрээс хамаарч ургамлан нөмрөгийн хувьд хэлбэлзэлтэй байх боловч бэлчээрийн хэв шинжид төдийлөн их ялгаа үзүүлэхгүй тул тусгаг бүрхэц уулын орой, хажуугаар 30-40 хувьд, хотгор хэсгээрээ 40-50 хувьд, хөндий хэсгээр 50-60 хувьд тус тус хэлбэлзэнэ.

Ургамлын ургалтанд гадаргын байдал зохих нөлөөтэй энэ нутагт байршилтай судалгааны талбайд 17 овгийн 39 төрлийн 54 зүйлийн ургамал бүртгэгдсэн. Эдгээрээс үетний, нийлмэл цэцэгтний, сарнайн овгийн ургамлууд хамгийн их тархацтай байж бэлчээрийн үндсэн хэв шинжийг бүрдүүлж байгаа бөгөөд ховор, нэн ховорт тооцогдох ургамал үгүй байна.

#### 2.5. Бүрэгхангай сумын нийгэм эдийн засгийн судалгаа

Тус сум нь анх 1923 онд Богд Хан уулын аймгийн Шажин-Бүрэг уулын хошуу

нэртэйгээр байгуулагдсан.

Улаанбаатар хотоос 265 км, Булган аймгийн төвөөс 86 км зайд оршдог. 349792 га газар нутагтай, үүнээс 282109 га нь бэлчээр, 10564 га нь хадлан 4361 га нь тариалангийн талбайд тооцогдож байна. Орхон ба Төв аймгийн Заамар сумтай хил залгаа оршдог. Тус сумын Бичигтийн голд Монголдоо томд тооцогдох хадны сүг зураг байдаг. Бүрэгийн нуруу, Дархан, Баянхангай, Шувуут, Их дулаан, Бага дулааны тахилгат хошуу 6 овоо, Шар хадны нуруу, Алтанга, Хутаг, Загзага, Эрдэнэ уул, Цоохор морьт зэрэг уулс, Орхон Туул зэрэг томоохон гол байдгаас гадна Ангирт, Шувуут, Бичигт, Хужирт, Хар бух гэх мэт 30 орчим гол горхи Булаг шанд, Дэлгэржаргалат, Ум, Хадат булгийн рашаанууд байдаг. Буга, бор гөрөөс, гахай, чоно, шилүүс, үнэг, дорго, туулай, тарвага зэрэг 20 гаруй ан амьтан мэрэгч байдаг. Хун, галуу, тогоруу, нугас, ангир, хөхөө, өвөөлж зэрэг нүүдлийн шувууд байдаг. Алтан гагнуур, бамбай, мэхээр, таван салаа, цээнэ зэрэг 20 гаруй төрлийн эмийн ургамлууд ургадаг. Дэд бүтэц, зам харилцаа сайн хөгжсөн. Улаанбаатар хот хүртэлх замын 205 км нь хатуу хучилттай. Эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон, үүрэн холбооны бүх сүлжээ орсон.

### 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслөөс байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөлөл нь багаас дунд зэрэг байх бөгөөд төслийн технологит ашиглагдаж буй техникийн хэрэглээг буруу ашигласнаас эвдрэл үүсэх мөн угсралтыг буруу гүйцэтгэх, санамсар болгоомжгүй байдлаас гал түймэр гарах зэрэг нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна.

Агаар: Уурхайн олборлолтын болон тээвэрлэлтийн үеийн тоосжилт, автомашины яндангаас гарах утаа зэрэг нь агаарын чанарт сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Ус: Баяжуулах үйлдвэрт ашиглах усыг гадаргын уснаас авч ашиглаж байгаа нь гадаргын усны нөөцөд сөрөг нөлөөлөл үзүүлж байна.

Хөрс: Төслийн хэмжээнд ашиглагдах 9.4 га газрын хөрсөн бүрхэвч нөлөөлөлд өртөнө.

Ургамал: Төслийн хэмжээнд ашиглагдах 9.4 га газрын ургамлан бүрхэвч нөлөөлөлд өртөнө.

Амьтан: Төслийн үйл ажиллагааны улмаас тус нутаг дэвсгэрт идээшилж амьдардаг амьтад үргэж дайжих улмаар идэш тэжээлээ олж идэх газар нутаг багасах, техник, тоног төхөөрөмжинд өртөх зэрэг сөрөг нөлөөлөл үүснэ.

Төсөл хэрэгжих үеийн сөрөг нөлөөллийн үнэлгээгээр гол сөрөг нөлөөлөл нь шинээр олборлолт явуулах үед хөрсөн бүрхэвч ба ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл байна.

Болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээний нэгдсэн дүнг дараах хүснэгт үзүүлэв.

Хүснэгт 9. Болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээний нэгдсэн дүн

№	Нөлөөлөл	Үнэлгээ							
		Эерэг				Сөрөг			
		Бүгд	Их	Бага	Дунд	Бүгд	Их	Бага	Дунд
1	Газрын гадарга					4	1		3
3	Агаарын чанар					4		2	2
4	Усан орчин					4		4	
5	Хөрсөн бүрхэвч					5	1		4
6	Ургамалан нөмрөг					6	3		3
7	Амьтны аймаг					3			3
8	Нийгэм, эдийн засаг	4	1		2				1

#### **4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, БОННҮнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Мөн төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага, зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгасан байх шаардлагатай.

Төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тухайн төслийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагааныхаа зардалд багтаан төлөвлөж зарцуулах.

Иймд “Гэрэлт шинэчлэл” ХХК нь байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах зорилгын хүрээнд 2023 оны БОМТөлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах зорилготой.

## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

### 5.1. Ордын ашиглалтын үед сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 10. Ордын ашиглалтын үед сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
1	<b>АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>					
	Уурхайн олборлолт болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд: - Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, овоолго хийх газар шорооны ажил, - Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, тээвэрлэлтэнд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох	Уурхайн талбайн үндсэн замуудыг хайрган хучилттай болгож, тоос босохоос сэргийлэх арга хэмжээ авах	Уурхайн ойр орчим	300.0	Уурхайн үйл ажиллагааны үед, нөхөн сэргээлтийн үе шатуудад	Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003 /ЗГ-ын 2013 оны 327 дугаар тогтоолын хавсралт- Ус ашигласны төлбөрийн хувь хэмжээ/ /БО-ны сайдын 1995 оны 153 дугаар тушаалын хавсралт 4-“Зүлэг, талбай усалгааны түр норм
		Тээвэрлэлтийн үед гарах тоос шороог багасгах үүднээс уурхайн дотоод болон гадаад замуудыг услах	Үйл ажиллагааны турш	ҮА зардал		
		Уурхайн машин механизмуудын янданд шүүлтүүр тавих	Үйл ажиллагааны турш	ҮА зардал		
	<b>Нийт дүн</b>			<b>300.0</b>		
	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
<b>2. ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>						
	Уурхайн хөрс хуулалт, олборлолт, овоолгууд бий болох түүнд дарагдах, хөрс хүдэр тээвэрлэлтийн улмаас хөрсний эвдрэл үүсэх	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх. Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон түүний явцад хуулан авсан шимт хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгалах.	2023 он	Нөхөн сэргээлтийн зардалд оруулсан	Барьж байгуулах болон үйл ажиллагааны үе шатуудад	MNS 5914:2008- Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт. MNS 5915:2008- Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS 5916:2008- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах, хадгалах техникийн шаардлага MNS 5917:2008- Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага MNS 5918:2008- Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага.
		Тогтсон маршрутын дагуу тээвэрлэлт хийх, олон салаа зам гарахаас сэргийлж гэмдэг, тэмдэглэгээ байрлуулах	Үйл ажиллагааны турш	200.0		
	Ил уурхай, овоолгууд, хаягдлын хуримтлалууд болон бусад холбогдох байгууламжийн үйл ажиллагааны улмаас газрын хэлбэр, төрхөд	Тухайн бүс нутагт уурхайн болон түүний дэд бүтцийн байгууламжуудтай холбогдон бий болсон газрын эвдэрлүүдийг багасгах	Үйл ажиллагааны турш	-		

“Бүрэг нэртэй алтны шороон ордыг ил болон драгын аргаар ашиглах” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	өөрчлөлт орох					MNS 4915:2000- Ашигт малтмал эрж хайх явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага. MNS 4920:2000- Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага
	Уурхайн ухаашууд, хоосон орон зай нь хүн амьтдад аюултай нөхцөл, эрсдэл үүсгэх	Овоолго хаягдын байгууламжуудыг бүтцийн хувьд тогтвортой болгох, нөхөн сэргээлт хийх	Үйл ажиллагааны турш	Нөхөн сэргээлтийн зардалд оруулсан		
	<b>Нийт дүн</b>			<b>200.0</b>		
	<b>Болзошгүй сөрөг нөлөөллүүд</b>	<b>Нөлөөллийг бууруулах арга хэмжээ</b>	<b>Арга хэмжээний цар хүрээ</b>	<b>Зардал /мян.төг/</b>	<b>Хэрэгжүүлэх хугацаа</b>	<b>Баримтлах эрх зүйн баримт бичиг,стандарт аргачлал</b>
<b>3</b>	<b>УСНЫ НӨӨЦ, ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>					
	Газрын доорх усыг авч ашигласнаар газрын доорх урсацын горим алдагдах, нөөц, чанарт нөлөөлж болзошгүй Түлш шатахуун, тослох материалууд, бохир ус, химийн янз бүрийн бодисууд алдагдах, асгарах зэргээс үүдэн бага гүнд орших уст давхарга бохирдох	Шатах тослох материалын агуулахыг эргэн тойрныг хатуу хучилттай болгох	2023 он	400.0	-	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль <b>MNS 4288:1995</b> <i>/ЗГ-ын 2013 оны 326 дүгээр тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/</i>
Олборлолтын ажлын явцад орчны тоосжилтыг бууруулахад газар доорх усны нөөцийг аль болох ашиглахаас зайлсхийж бороо хурын усыг цуглуулж ашиглах усанд сан хийх		2023-2024 он	-	-		
Ус ашиглах дүгнэлт гаргуулж төлбөрийг төлөх		Үйл ажиллагааны турш	-	-		
Ус ашиглалтын гэрээг холбогдох орон нутгийн болон бусад холбогдох байгууллагатай хийж баталгаажуулах, төлбөрийг цаг тухай бүр төсвийн дансанд оруулах		Үйл ажиллагааны турш	-	-		
	<b>Нийт дүн</b>			<b>400.0</b>		
	<b>Болзошгүй сөрөг нөлөөллүүд</b>	<b>Нөлөөллийг бууруулах арга хэмжээ</b>	<b>Арга хэмжээний цар хүрээ</b>	<b>Нэгжийн өртөг /мян.төг/</b>	<b>Хэрэгжүүлэх хугацаа</b>	<b>Баримтлах эрх зүйн баримт бичиг,стандарт аргачлал</b>
	<b>УРГАМЛАН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>					
	Ил уурхай, хаягдал чулуулгийн овоолгод ургамлан бүрхэвч устах, дарагдах Төслийн болон түүний эргэн тойрны нутаг	Уурхайн хилийг тойруулан хашаалж, хөндөглөөгүй ургамалжсан газруудад мал, амьтан бэлчээрлэхээс сэргийлэх. Уурхай болон төслийн талбайд үйл ажиллагаа явуулж буй бусад газруудыг мөн хашаалах	Үйл ажиллагааны турш	ҮА зардал	-	Ургамал хамгааллын тухай хууль



*“Бүрэг нэртэй алтны шороон ордыг ил болон драгын аргаар ашиглах” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

<p>дэвсгэрийн дэд бүтэц болон замын байгууламжуудын нөлөөлөлд өртөж талхлагдах Автомашин хөдөлгөөн, овоолго, тээвэрлэлт зэрэг төслийн үйл ажиллагаанаас үүсэх</p>	<p>Хөрсний овоолго, хаягдал хадгалах байгууламжийн дээр ургамлан нөмрөгийн нөхөн сэргээх ажлыг уурхайн ашиглалтын явцад боловсруулсан нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу уурхайн ашиглалтын хугацааны туршид тасралтгүй явуулах</p>	<p>Үйл ажилллагааны турш</p>	<p>Нөхөн сэргээлтийн зардалд багтсан</p>	<p>Жил бүр</p>	
<p>тоосжилт нь ургамал дээр унаж хуримтлагдаж болзошгүй ба энэ нь цаашдаа ургамал үхэх, ургалт доройтох нөхцлийг бүрдүүлэх</p>	<p>Зарим ашиглагдаагүй байгаа замууд, хайгуул, судалгааны ажлаар эвдэгдсэн газруудыг эдгээр газрууд нь бусад төсөл, үйл ажиллагаа, дэд бүтцийн зорилгоор дахин ашиглагдахгүй бол нөхөн сэргээх ажлыг уурхайн үйл ажиллагааны эхний үе шатанд хэрэгжүүлэх</p>	<p>Үйл ажилллагааны турш</p>	<p>400.0</p>	<p>Жил бүр</p>	
<b>Дүн</b>			<b>400.0</b>		
<b>Болзошгүй сөрөг нөлөөллүүд</b>	<b>Нөлөөллийг бууруулах арга хэмжээ</b>	<b>Арга хэмжээний цар хүрээ</b>	<b>Нэгжийн өртөг /мян.төг/</b>	<b>Хэрэгжүүлэх хугацаа</b>	<b>Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал</b>
<b>АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>					
<p>Төслийн болон ойр орчны нутаг дэвсгэр дэх уурхайн болон дэд бүтцийн үйл ажиллагаа, ашиглалттай холбоотойгоор амьтны аймгийн нутагшил үгүй болох</p>	<p>Төслийн ажиллагсад болон гэрээлэгчдийг галт зэвсэг хэрэглэхгүй байх болон ан агнуурын талаарх бодлогыг мөрдүүлэхэд анхаарах</p>	<p>Орон нутгийн хэмжээнд</p>	-	-	
<p>Хөхтөн, шувууд зэрэг амьтдыг дуу чимээ, гэрэл, машин техникийн ажиллагаа зэрэг уурхайн үйл ажиллагааны улмаас үргээж, дүрвээх ба айлган цочоож болзошгүй Технологи болон хүний үйл ажиллагаагаар бий болсон орчинтой холбоотойгоор шавьжнуудын тоо толгой нэмэгдэж болзошгүй (шавьжнууд гэрэлд амархан татагддаг)</p>	<p>Уурхайн талбайд мал гэмтэхээс сэргийлэн хашаалах</p>	<p>Уурхайн талбайн хэмжээнд</p>	300.0	-	Амьтны тухай хууль

Дүн		300.0	
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ			
Энэхүү тайлангийн сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны турш	-	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм,  Галын аюулгүй ажиллагааны дүрэм  <a href="#">ISO 14001:2004 Байгаль Орчны Удирдлагын Тогтолцоо</a>
Уурхайн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулж, хамруулах	Үйл ажиллагааны турш	Жил бүр	
Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох дүүргийн байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Үйл ажиллагааны турш	Жил бүр	
Ажиллагсдыг жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах.	41 хүн* 60.0 =2460.0 ҮА зардал	Жил бүр	
Гал унтраах хэрэгслээр уурхайг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах	300.0	Жил бүр	
Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 10 <sup>1</sup> дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны аудитыг 2 жил тугамд хийлгэх Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдтэй харилцан тохиролцох	Гэрээгээр зохицуулагдана.	Ашиглалтын 2 жилийн хугацаанд 1 удаа	
Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 2 жил тугамд хийлгэх		Ашиглалтын 2 жилийн хугацаанд 1 удаа	
Нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн иргэдтэй хамтарч ажиллах	Саналаар	Жил бүр	
<b>Дүн</b>		<b>300.0</b>	
<b>НИЙТ ДҮН</b>		<b>1900.0</b>	

## 5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

### Техникийн болон биологийн нөхөн сэргээлт

2023 онд уурхайн ашиглалтын явцад биологийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй бөгөөд дотоод овоолго дээр техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэхээр байна.

Хүснэгт 11. Нөхөн сэргээлтийн зардал

Үзүүлэлт	Гүйцэтгэх ажил	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгж зардал мян.төг	Зардал мян.төг	
1	Биологийн нөхөн сэргээлт	2023 онд биологийн нөхөн сэргээлтийн ажил явагдахгүй	Шимт хөрсний арчилгаа 0.5 га	-	1500.0
			Шимт хөрсийг тэвэрлэж засч тэгшлэх	-	Үйл ажиллагааны зардал
2	Техникийн нөхөн сэргээлт	Дотоод овоолго дээр 2.5 га-д байршуулна.		2500.0	Үйл ажиллагааны зардал
<b>Нийт</b>				<b>1500.0</b>	

### Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг 3.1.11-д “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг ойлгоно гэж заасан байдаг. Ашигт малтмалын ашиглалтын нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага бий болсон тул биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээлт хийх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг дараах хүснэгтэнд тодорхойлсон болно.

Хүснэгт 12. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Зардал мян.төг	
1	Булгийн эхийг хамгаалах	Булгийн эхийг хашиж хамгаалах	Булган аймгийн Бүрэгхангай сумын Цахт багийн Дөрөлжийн булаг	3000.0 ҮА зардал
2	Тэрбум мод тарих хөдөлгөөн	Мод, бут сөөг (500ш)	Бүрэгхангай сум, 103° 53' 04.41" 48° 14' 55.05"	2500.0
<b>Нийт</b>			<b>2500.0</b>	

## 5.3. Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллагыг зайлшгүй нүүлгэх шаардлагатай болсон “Ашигт малтмалын тухай” хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна. 2023 онд тус төслийн үйл ажиллагаатай холбоотой нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох арга хэмжээ хийгдэхгүй болно.

## 5.4. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд хийсэн археологийн судалгаа, түүх соёлын өвийн судалгааны дүн, түүх, соёлын өв дурсгалуудын талаарх нутгийн иргэд, холбогдох байгууллагын мэдээлэлд үндэслэн түүх, соёлын өв дурсгалуудыг хамгаалах төлөвлөгөө боловсруулна. Энэ төлөвлөгөөнд үйлдвэрлэл дэд бүтцийн байгууламжийг барьж байгуулах, ашиглах болон үйл ажиллагааны явцад илэрсэн түүх, соёлын өвийг хэрхэн хамгаалах арга хэмжээ авах талаар тусгана.

## 5.5. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 13. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Зардал мян.төг	Баримтлах стандарт, аргачлал
<b>Байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр</b>					
1.	Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс уурхайн үйл ажиллагаа доголдох, зогсох	Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах	Булган аймгийн Бүрэгхангай	-	Ус цаг уур, орчны хяналт Шинжилгээний тухай хууль, 15-р зүйл MNS 4585:2007
2.	Гал түймрийн улмаас үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах	Төслийн хэмжээнд	ҮА-ны төлөвлөгөөнд тусгах	Галын аюулгүй байдлын тухай хууль, 16-р зүйл, MNS 5566:2005 MNS 0640:89 MNS 639:89
3.	Газар хөдлөлт, чичирхийллийн улмаас үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Болзошгүй ослын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Төслийн хэмжээнд	-	Гамшигаас хамгаалах тухай, 27-р зүйл
<b>Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр</b>					
4.	Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох,	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	Төслийн хэмжээнд	ҮА-ны төлөвлөгөөнд тусгах	MNS 4990:2000
		Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх			MNS 4969:2000
		Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах		ҮА-ны төлөвлөгөөнд тусгах	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль 15-р зүйл
		Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавьж, засвар үйлчилгээг тогтмол хийж байх			
<b>Эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ</b>					
5.	Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх эрсдэл	Салхи ихтэй, тоосжилт үүсэх улиралд тоосжилтыг бууруулах арга хэмжээг тогтмол авах	Төслийн хэмжээнд	Хяналт шинжилгээний зардалд багтсан	MNS5885:2008 MNS6148:2010 MNS4943:2015
		Орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн шинжилгээ үр дүнг магадлан итгэмжлэгдсэн хөндлөнгийн лабораториор баталгаажуулах			
		Шимт хөрсний овоолгын бүрэн бүтэн байдалд хяналт тавьж байх.	Уурхайн шимт хөрсний овоолго	ҮА-ны төлөвлөгөөнд тусгах	
<b>Нийт</b>				<b>ҮА зардал</b>	

5.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Зардал /мян.төг/	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хөрс, ус, агаарын бохирдол үүсгэх	Хог хаягдлыг тогтоосон журмын дагуу кодлон ангилж, дахин ашиглах зайлуулах арга хэмжээнүүдийг тодорхойлох	Төслийн талбай	-	Жил бүр	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд MNS 5850:2008 MNS ISO11074-1:2001 Олон улсын стандартын дагуу, Засгийн газрын 2002 оны 135 дугаар тогтоолын хавсралт Аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, Савлах, түр байршуулах, тээвэрлэх, аюулгүй болгох, хадгалах, устгах журам Хог хаягдлын тухай хууль, 2017 он Нүхэн жорлон, угаасны нүх, Техникийн шаардлага MNS 5924:2015
	Хог хаягдлыг нэг цэгт цуглуулан ангилж, битүү саванд хадгалан тогтмол хугацаанд тээвэрлэж байх	Төсөл хэрэгжих орчин	300.0	Жил бүр	
	Хөрсийг тос тосолгооны материалаар бохирдуулахыг хориглох, тосоор бохирдсон хөрсийг эрүүлжүүлсэний дараа хуулсан хөрс чулуулгийн овоолгод шилжүүлэх	Төслийн талбай	ҮА-ны зардал	Жил бүр	
	Бүх төрлийн дахин ашиглах боломжтой хог хаягдлын ангилан холбогдох байгууллагуудад тушаах	Төсөл хэрэгжүүлэгч		Жил бүр	
	Техникийн засвар үйлчилгээг агуулахын нутаг дэвсгэрт хийж ажилласан тос хөрсөнд асгарах, алдагдахаас сэргийлэх	Төсөл хэрэгжих орчин		Жил бүр	
	Одоо ашиглаж буй бие засах газар нь хөрс, газрын доорх ус бохирдуулах аюултай бөгөөд Хог хаягдлын тухай хуулийн дагуу ариутгал халдваргүйжүүлэлт хийж байх	Ажилчдын бие засах газар буюу нүхэн жорлон		300.0	
	Доторлогоотой соруулдаг нүхэн цооног байгуулах	Үйл ажиллагааны турш	1200.0	2023 он	
	Хаягдал хөдөлгүүрийн тосыг тусгай төхөөрөмж ашиглан дахин ашиглах, бусад тосолгооны материалын хаягдал болон дугуй аккумулятор зэргийг тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан хүлээлгэж өгөх	Үйл ажиллагааны турш	-	Жил бүр	
<b>Физик нөлөөллийг бууруулах чиглэлээр</b>					
Үйлдвэрийн тоног төхөөрөмж, машин механизмын, хөдөлгүүрээс үүдэлтэй шуугиан ажиллагсдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлнэ.	Техник тоног төхөөрөмжийн шуугиан бууруулах арга хэмжээг авах	Төслийн талбай	ҮА-ны зардал	Жил бүр	MNS 5003:2000
	Дуу шуугиан ихтэй ажлын байранд ажиллагсдыг сонсголын эрхтэн хамгаалах хэрэгслээр хангах	Шуугианы түвшин өндөр хэсгүүд			
<b>Нийт</b>			<b>1800.0</b>		

## **6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

“Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 3.1 дүгээр зүйл, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуульд зааснаар төслийг хэрэгжүүлэх явцад төслөөс байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) гэнэ.

Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр нь “Бүрэг нэртэй алтны шороон ордыг ил болон драгын аргаар ашиглах” төсөл хэрэгжиж буй бүс нутагт гарч болзошгүй өөрчлөлтүүдийг эрт тодорхойлох, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны үр дүнг тайлагнах, авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа, хяналтын байгууллага, нутгийн оршин суугчдад байгаль орчин, амьдрах орчны өөрчлөлтийн талаар бодит мэдээлэл өгөх үндсэн зорилготой.

Төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх мөн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад байгаль орчны төлөв байдалд өөрчлөлт орох, бохирдлын хэмжээ нь байгаль орчны стандарт, норм нормативаар тогтоосон хэмжээнээс хэтэрч илрэх тохиолдолд мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Уг хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжих газрын агаар, усны чанар, хөрс, амьтан, ургамлын асуудлыг онцлон анхааран авч үзсэн бөгөөд байгаль орчны бохирдол, өөрчлөлтийг хянах гол үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх давтамж, шинжлэх арга, дээж авах, хадгалах, тээвэрлэх шинжлэхэд баримтлах стандарт шаардлага зэргийг багтаасан болно. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол улсын хууль тогтоомж, стандарт, дүрэм, заавар арга зүйг баримтлах шаардлагатай.

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	БО-ны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг	Баримтлах стандарт, аргачлал	Дээд доод хязгаар
<b>Агаарын чанар, бохирдлын мониторинг</b>							
Тоос: PM2.5, PM10, Нийт тоос Утааны хий: Хүхэрлэг хий, Азотын давхар исэл, Угаарын хий	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 2 цэг сонгох зонхилох салхины доод ба дээд талд	Жилд 2 удаа	Уурхайлалт явагдаж буй талбайд	120.0	280.0	MNS 0017-2-5-12:1988 MNS ISO 4221: 2002 MNS0012-1-003:1982 MNS 0017-2-5-11:1988 MNS 4048:1988 ISO 16017-1:2000 ISO 16362-2:2003 MNS 5365:2004	24 цагийн дундаж: Нийт тоос-150 мкг/м <sup>3</sup> PM2.5-50 мкг/м <sup>3</sup> PM10-100 мкг/м <sup>3</sup> SO <sub>2</sub> -20 мкг/м <sup>3</sup> NO <sub>2</sub> -40 мкг/м <sup>3</sup> CO-30000 мкг/м <sup>3</sup>
	Драгын талбай, хөрсний овоолго 2 цэг		Уурхай болон үйлдвэрийн үйл ажиллагаанаас орчинд тоосжилт үүсэх, тархах	100.0			
	Хүнд даацын машины тээврийн зам, баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн орчим		Машин механизмын ажиллагаа, хөдөлгөөнөөр шуугиан үүсэх	60.0			
Дүн /мян.төг/					<b>280.0</b>		
<b>Усны нөөц, чанар, бохирдлын мониторинг</b>							
Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Ундны ус авч хэрэглэж буй уст цэг	Үйл ажиллагааны үед жилд 2 удаа	Төслийн талбай орчим	120.0	240.0	MNS6148:2010 Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ	Газрын доорхи ус: рН-6.5 – 8.5 NH <sub>4</sub> - 3.0 мгN/л NO <sub>2</sub> – 1 мг/л NO <sub>3</sub> - 50 мг/л PO <sub>4</sub> – 3.5 мг/л Cl – 350 мг/л F – 1.5 мг/л SO <sub>4</sub> -500 мг/л Mn-0.1 мг/л Ag-0.1 мг/л Fe-0.3 мг/л
	Технологийн усны хэрэглээний эх үүсвэр буюу гадаргын ус			120.0			
Дүн /мян.төг/					<b>240.0</b>		
<b>Хөрсний чанар, бохирдлын мониторинг</b>							
Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс%, ялзмагийн агууламж%, шим	Төслийн талбайд 4 цэг сонгох ШТМ түгээх цэгийн орчим болон олборлолтод өртөөгүй цэгт Угаан баяжуулах	Жилд 2 удаа	Хөрсний элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	120.0	260.0	MNS 2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам; MNS 3298-1991 Шинжилгээний дээж авахад	Pb-100 мг/кг Cd-3 мг/кг As-6 мг/кг Cu-100 мг/кг Zn-300 мг/кг

*“Бүрэг нэртэй алтны шороон ордыг ил болон драгын аргаар ашиглах” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

гэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	үйлдвэрийн хашаанд Тунгаах нуурын орчим					тавигдах ерөнхий шаардлагууд; MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ; MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	
Хүнд металлын агууламж	Дээрх 4 цэгт	Жилд 2 удаа	Түлш, тосолгооны материал болон химийн бодис, хог хаягдлаар хөрс бохирдох Угаан баяжуулах үйлдвэрийн хашаанд Тунгаах нуурын орчим	140.0			
Дүн /мян.төг/						<b>260.0</b>	
Нийт /мян.төг/						<b>780.0</b>	

**6.1. БОМТ-ний хэрэгжилтийн талаар нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө**

Төсөл хэрэгжүүлэгч “Гэрэлт шинэчлэл” ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ. Төсөл хэрэгжүүлэгч нь нутаг дэвсгэрийн сум, багийн нийтийн иргэдийн хуралд БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ.

